

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр

1. “Монголросцветмет” ХХК нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020580 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх, ажлын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж хамгаалах зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020580 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх, ажлын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэснээр компаний харьяа Зэрэгцээ алтны үйлдвэрийн алт олборлолтыг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх, хүрээлэн буй орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
- Геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
- Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл мэдээлэл /сүүлийн 2 жилийн буюу 2016 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх, 2017 оны баталгаажсан санхүүгийн тайланг нотариатаар гэрчлүүлсэн байх/,
- Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
- Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

3.1. Сүүлийн 3 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2018 оны 01 дүгээр сарын 30–ны өдрийн 10 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2018 оны 02 дугаар сарын 01 – ний өдрийн 10 цагаас өмнө дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

“Монголросцветмет” ХХК

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ХХК-ын байр, 504 тоот,

И-мейл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-158